МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ОРОН НУТГИЙН УДИРДАХ АЖИЛТНЫ УЛСЫН ЗӨВЛӨГӨӨН

БАТЛАН ХАМГААЛАХЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Батлан хамгаалахын дэд сайд
Т.ДУЛАМДОРЖ

2019.02.22

БАТЛАН ХАМГААЛАХ ТОГТОЛЦОО

Орон нутгийн хамгаалалт | **Зэвсэгт хүчин** | **Дайчилгаа**

БАТЛАН ХАМГААЛАХЫН ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс

Батлан хамгаалахын багц хууль

- Монгол Улсын батлан хамгаалах тухай
- Зэвсэгт хүчний тухай
- Цэргийн албаны тухай
- ЦАХ-ийн эрх зүйн байдлын тухай

- Дайчилгааны тухай
- Орон нутгийн хамгаалалтын тухай

6 бүлэг, 24 зүйл, 52 хэсэг, 84 заалттай

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ

Өөрийгөө хамгаалах стратеги, батлан хамгаалах тогтолцооны тулгуур үндэс

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТ

Орон нутгийн хамгаалалт нь түүний бэлтгэлийг хангах, хамгаалахтай холбогдсон төлөвлөлт, зохион байгуулалт, удирдлагын үндсэн арга хэмжээнээс бүрдэнэ.

Орон нутгийн хамгаалалтыг зэвсэгт хүчний үйл ажиллагаа, улсын болон цэргийн дайчилгааны бодлого, төлөвлөгөөтэй уялдуулна.

Орон нутгийн хамгаалалтын үндсэн нэгж нь **аймаг, нийслэл** байна.

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТ

Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй байгууллагын **орон нутаг дахь нэгжийг** орон нутгийн хамгаалалтад оролцуулна.

Орон нутгийн хамгаалалтад **зэвсэгт хүчний** цэргийн нэгтгэл, анги, байгууллага, салбарыг оролцуулж болно.

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН УДИРДЛАГА

Улсын хэмжээнд орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг зохион байгуулах, хянан зохицуулах чиг үүргийг **батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага** хэрэгжүүлнэ.

Орон нутгийн хамгаалалтыг нутаг дэвсгэрийн зарчмаар **аймаг, нийслэлийн Засаг дарга** зохион байгуулна.

Дайны байдлын үеийн орон нутгийн хамгаалалтын зэвсэгт тэмцлийн удирдлагыг **цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага** хэрэгжүүлнэ.

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ҮНДСЭН АРГА ХЭМЖЭЭ

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ҮНДСЭН АРГА ХЭМЖЭЭ
орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангах, уламжлалт аюулаас урьдчилан сэргийлэх, уламжлалт бус аюулаас хамгаалах, онц болон дайны байдлын үед орон нутгаа хамгаалах замаар улсыг батлан хамгаалахад дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ТАЙВАН ЦАГИЙН АРГА ХЭМЖЭЭ

Эдийн засаг, нийгмийн бие даасан, тогтвортой хөгжлийг хангах

Иргэний эрүүл мэнд, боловсролыг дэмжих

Орон нутгийн хамгаалалтыг төлөвлөх

Иргэнд эх оронч хүмүүжил төлөвшүүлэх

Орон нутгийн хамгаалалтын нөөцийг бүрдүүлэх

Уламжлалт бус аюулаас хамгаалах

Орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангах, зохион байгуулах

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ОНЦ БОЛОН ДАЙНЫ БАЙДЛЫН ҮЕИЙН АРГА ХЭМЖЭЭ

Орон нутагт онц болон дайны байдлын үед тогтоосон дэг журмыг сахиулах

Хүн амын зайлшгүй хэрэгцээт зүйлийг хангах

Цагийн байдлын мэдээ, мэдээлэл харилцан солилцох

Гамшиг, хөнөөх хэрэгслийн хөнөөлөөс иргэн, эд хөрөнгийг авран хамгаалах

Орон нутгийн иргэд, засаг захиргаа, эдийн засаг, нийгмийн чухал обьектыг хамгаалах

Зэвсэгт хүчний цэргийн нэгтгэл анги, байгууллага, салбарын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

Дайсан этгээдийн тагнуул, хорлон сүйтгэх болон террорист бүлэгтэй тэмцэх

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН НӨӨЦ

Аймаг, нийслэл нь орон нутгийн хамгаалалтын үндсэн арга хэмжээг хэрэгжүүлэх нөөцтэй байна.

Томилгоот иргэн, хуулийн этгээд

Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгж

Даалгаваржуулсан галт зэвсэг, техник, материал хэрэгсэл

Тусгайлан бүрдүүлсэн материал хэрэгсэл, санхүүгийн нөөц

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ТОМИЛГООТ НЭГЖ

Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийг дараах үүрэг гүйцэтгүүлэхээр бэлтгэнэ.

Орон нутагт онц болон дайны байдлын үед тогтоосон дэг журмыг сахиулахад дэмжлэг үзүүлэх

Орон нутгийн засаг захиргаа, эдийн засаг, нийгмийн чухал обьектыг хамгаалах

Дайсан этгээдийн тагнуул, хорлон сүйтгэх болон террорист бүлэгтэй тэмцэх

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ТОМИЛГООТ НЭГЖ

Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийг дараах үүрэг гүйцэтгүүлэхээр бэлтгэнэ.

Зэвсэгт хүчний цэргийн нэгтгэл, анги, байгууллага, салбарын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

Гамшиг, хөнөөх хэрэгслийн хөнөөлөөс иргэд, эд хөрөнгийг авран хамгаалахад дэмжлэг үзүүлэх

Дайны байдлын үед хүн амын амьжиргааны зайлшгүй хэрэгцээт зүйлийн хангалтыг зохион байгуулах

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН СУРГАЛТ

Орон нутгийн хамгаалалтын сургалтыг бие даасан болон ҮАБХТЧБ-ын сургалттай хамтарч явуулж болно.

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын
- Томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний
- Томилгоот нэгжийн бүрэлдэхүүний



- Цугларалт
- Хээрийн дадлага
- Нэгдсэн сургууль



Цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага дэмжлэг үзүүлнэ.

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ

Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөтэй байна.

Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн аймаг, нийслэлийн орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг батална.

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ

“Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүтэц, зохион байгуулалтын үлгэрчилсэн загвар”, “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө боловсруулах заавар” зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг батлан аймаг, нийслэлд хүргүүлж, орон нутгийн хамгаалалтын төлөвлөлтийг эхлүүлээд байна.

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТ

Орон нутгийн хамгаалалтын тухай хууль батлагдсанаар иргэний **“Эх орноо хамгаалах”** Үндсэн хуулийн заалт хэрэгжих нөхцөл бүрдэж, Монгол Улсын өөрийгөө хамгаалах чадавх нэмэгдэн, орон нутгийн өөрийгөө хамгаалах нийгэм, эдийн засгийн чадамжийг дээшлүүлэх замаар орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцооны цогц байдал хангагдана.

Анхаарал хандуулсанд баярлалаа.